

20 24 оны 10 сарын 15-ны өдөр

№ 22

Улаанбаатар хот

*Итгэлцлийн үйлчилгээний журмын хавсралтад
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.17 дахь хэсэг, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6.3 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 434 тоот тогтоолоор батлагдсан “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ын Гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хөрөнгө итгэмжлэх гэрээ”-нд хавсралт ёсоор нэмэлт, өөрчлөлт оруулсугай.
2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ




20 ²⁴ оны ¹⁰ сарын ¹⁵ -ны өдөр

№ ²⁴

Улаанбаатар хот

Зээл авах их хэмжээний хэлцэл байгуулахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компани нь гадаадын хөрөнгө оруулалт татах зорилгоор 10,000,000 (арван сая) ам.долларын зээлийг 36 (гучин зургаа) сарын хугацаатай, жилийн 13 (арван гурав) хувийн хүүтэй зээл авах зөвшөөрөл олгож, холбогдох их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Зээлийн үүргийн гүйцэтгэлийн хангах зорилгоор Зээлдэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд заасан компанийн зээлийн багцыг барьцаалахыг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хөрөнгө оруулалт татах зорилгоор холбогдох этгээдүүдтэй гэрээ, хэлцлийг байгуулах, түүнтэй холбоотой баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Санхүү хариуцсан захирал /Б.Батжаргал/ нарт олгосугай.
4. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж ажиллахыг Эрсдэл хяналт шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/, Санхүү хариуцсан захирал /Б.Батжаргал/ нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



20~~27~~²⁴ оны ~~10~~¹⁰ сарын ~~15~~¹⁵ -ны өдөр

№ ~~24~~²⁵

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг чөлөөлж,
орлон ажиллах гишүүнийг түр томилох тухай*

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.11 дэхь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Баатархүү овогтой Анужин /РД: ШУ89020805/ нь чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн гишүүнийг орлон ажиллах хараат бус гишүүнээр Чойжилсүрэн овогтой Заяа /РД: УП95040209/-г компанийн хараат бус гишүүний нөхөн сонгууль хүртэл хугацаагаар түр томилсугай.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүнтэй холбогдох гэрээг байгуулах арга хэмжээг авах, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсон өөрчлөлтийг зохицуулагч байгууллагуудад зохих журмын дагуу мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Цэлмэг/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 ²⁴ оны ¹⁰ сарын ¹⁵ -ны өдөр

№ ²⁶

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүтцэд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгүүдийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Баатархүү овогтой Анужин үүрэг ажлаасаа чөлөөлөгдсөн тул түүний эрхэлж байсан ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга болон Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Компанийн хараат бус гишүүнээр түр томилогдсон Чойжилсүрэн овогтой Заяа /РД: УП95040209/-г ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга болон Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр томилсугай.
3. Хараат бус гишүүнээр түр томилогдсон Ч.Заяа нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцийг энэхүү өөрчлөлтийн дагуу хэвээр үлдээсүгэй.
4. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг зохицуулагч байгууллагуудад зохих журмын дагуу мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Цэлмэг/-г даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ


УЛААНБААТАР ХОТ ХТТ 100000